



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1.Барилгын түр хашаа болон гэр хорооллын хашааг дээврийн төмрөөр хийлгэхгүй байх талаар анхаарч иргэдэд мэдээлэл хүргүүлэх. Хотын хэмжээнд үзлэг хийж эвдэрсэн муудсан хашааг буулгах, шинэчлэх ажлыг эрчимжүүлэх. (Нутгийн удирдлагын баруун талын хашаа, сүмийн уулзварын урд хашаа гэх мэт)

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ГХБХБГ

Барилга байгууламжийн угсралтын талбайд баригдсан түр хашааны эвдрэл гэмтэл нь иргэдийн аюулгүй зорчих байдалд сөргөөр нөлөөлсөн, барилгын суурь шороог зөвшөөрөлгүй асгасан, эзэмшиж байгаа газрын хэмжээнээс илүү гаргаж хашаалсан зөрчилтэй 15 аж ахуйн нэгж, 32 иргэнд 2024 оны 09 дугаар сарын 08-ны дотор хариу ирүүлэх хугацаатай албан мэдэгдлийг хүргүүлсэн. Албан мэдэгдлийн дагуу 7 аж ахуйн нэгж зөрчилтэй холбоотой хариу ирүүлээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна

ЧАНДРАМДАА - АНУЖДА



Биелэлт: ХББЗА

Он дамжсан барилга болох Рашаант багийн 250 хүүхдийн сургуулийн барилга, Говил багийн 250 хүүхдийн сургуулийн барилга, Наран багийн 250 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын хашааг шинэчлэн солих тухай албан бичгийг гүйцэтгэгч компаниудад хүргүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Гэр хорооллын хашааг дээврийн төмрөөр хийхгүй байхыг анхааруулсан мэдээлэл бэлтгэж Баян-Өндөр сум болон багуудын ажлын албаны цахим хуудсаар дамжуулан 7836 иргэнд хүргээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





2. Хотын хэмжээнд их цэвэрлэгээ хийх хуваарь гаргаж байгууллагуудад хүргүүлэх. (Цэвэрлэгээ хийгээгүй аж ахуй нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллах)

Хугацаа: Ойрын хугацаанд






Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/257 дугаартай "Хотын их цэвэрлэгээ зохион байгуулах тухай" захирамжийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээнд хамрагдаагүй аж ахуй нэгжид албан мэдэгдэл хүргүүлснээр 54 аж ахуй нэгж, байгууллага 1028м үерийн далан, 1.1 га талбайн хог цэвэрлэгээ, 0.9 га талбайн шарилжийг цэвэрлээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





Биелэлт: Жаргалант сумын ЗДТГ

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хог хаягдал, шарилж цэвэрлэх ойр орчмын 50 метр талбайн хуваарийг байгууллага тус бүрд хүргүүлсэн. Бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 10 аж ахуйн нэгж, байгууллага оролцож 7.8 га талбайн хог хаягдлыг цэвэрлээд байна. Мөн сумын төвийн хатуу хучилттай авто замын хог, шороог төсвийн байгууллагуудын оролцоотойгоор цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



3. Гэр хорооллын гудамж хоорондын зам засварын ажлыг яаралтай эхлүүлэх.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Баян-Өндөр сумын болзошгүй аваарын зардлаас бороо үерийн улмаас эвдрэл ихээр үүссэн гэр хорооллын шороон замыг сэргээн, засварлах ажилд хөрөнгө гаргаж, ХТГ-тай хамтран зам засварын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлүүлэн Уртын гол, Рашаант багт 16 байршилд 3595м шороон зам тэгшлээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна

ЧАНДРАМДАА - ДУУЖДА



4. Ногоон байгууламж дээр авто машин гаргаж тавьсан, авто зам болон явган хүний зам давж эвдрэл үүсгэж байгаа асуудлыг цэгцлэх, хариуцлага тооцдог байх.

Хугацаа: Тухай бүрд






Биелэлт: ЦГ

Ногоон байгууламж болон явган хүний зам дээр авто машин тавьж, эвдрэл үүсгэж байгаа зөрчлийг арилгахаар багийн засаг дарга нартай хамтран сануулах хуудас тарааж байна. Мөн зөрчил дутагдлыг давтан гаргасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох санамжуудыг тараах ажлыг зохион байгуулж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





5. Нийтийн тээврийн шинээр явж буй чиглэлүүдийг тодорхой болгон холбогдох шийдвэрийг гаргаж иргэдэд мэдээлэл өгөх.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: АТТ

1. Ч-5 буюу Хүлэг зах-Автобуудал-Говил чиглэл
2. Ч-8 буюу Даниста-Урд хабитат-Дэнж-Уртын гол чиглэлүүдэд тус бүр 4 автобус 17-20 минутын давтамжтай зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж байна.

Тус чиглэлүүдийн маршрутын зураглал болон батлагдсан цагийн хуваарийг хотын доторх автобус, автобусны буудлуудад байршуулсан. Мөн Орхон аймгийн Автотээврийн төв пэйж хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



6. Нийтийн эзэмшлийн талбайд худалдаа эрхэлж байгаа асуудлыг цэгцлэх (машины авто зам, нийтийн тээврийн зогсоол дээрх худалдааг нэн даруй зогсоох)

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Хангарьд спорт цогцолборын ард ил задгай худалдаа эрхэлж байгаа 6 иргэнд зөвшөөрөлгүй худалдаа эрхэлж байгааг зогсоох хугацаат мэдэгдэл хүргүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





7. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа бүрэн хийж дуусгахад анхаарах, эрчимжүүлэх.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХЗА

Хотын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 75 хувьтай хэрэгжиж байна. 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар бүрэн хэрэгжиж дууссан 12, 50-95 хувийн хэрэгжилттэй 30, 10-45 хувийн хэрэгжилттэй 8 ажил байна. 2024-2025 оны хотын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК-ийн гүйцэтгэж байгаа 8 ажил дээр холбогдох мэргэжилтнүүдийг байлцуулан үзлэг хийсэн. Халаалтын улирал эхлэхтэй холбогдуулан инженерийн шугам сүлжээний засварын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



Биелэлт: ХХААГ

Монгол Улсын Засгийн газрын 28 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 02 дугаар албан даалгавар, аймгийн ИТХ-ын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд мал аж ахуйн чиглэлээр 12 ажил тусгагдсан. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас 30 хувьтай 3, 50 хувьтай 1, 70 хувьтай 3, 90 хувьтай 3, 100 хувийн гүйцэтгэлтэй 1, хугацаа хүлээгдэж байгаа 1 арга хэмжээ байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



8. Засгийн газраас тогтоосон нөөцөд авах өвс, тэжээлийг ойрын хугацаанд бэлтгэхэд анхаарах. Тендерийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХХААГ

Монгол улсын Засгийн газрын 28 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 02 дугаар албан даалгавар, аймгийн ИТХ-ын 19/03 дугаар тогтоолын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэхээр орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж, өвс, тэжээл худалдан авах техникийн тодорхойлолтыг ОНӨГ-т хүргүүлсэн.

"Тугчинбаатар" ХХК аймгийн аюулгүйн нөөцийн 60 тн өвс, 25 тн тэжээл нийлүүлэх тендерт шалгарч гэрээнд заасан хугацаанд (2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор) нийлүүлэхээр болсон. Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг ажлын хэсэг хүлээн авахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

МАНРАМДАА-ДРЭЖБА